



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 1/435

Улаанбаатар хот

Г

Г

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээний хүрээнд Эмнэлгийн түргэн тусlamжийн бүрэн тоноглогдсон машин 7 ширхэг, нийт 700,000,000 /долоон зуун сая/ төгрөг, Эмнэлгийн түргэн тусlamжийн хагас тоноглогдсон машин 6 ширхэг нийт 300,199,998 /гурван зуун сая нэг зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн найман/ төгрөгийн төсвийг зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга /Л.Төмөрбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан, ажлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга /Л.Төмөрбаатар/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081453